

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2017 оны 08 дугаар сарын 14-ний өдөр

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын Засаг даргын Тамгын газар нь 2017 оны Орон нутаг хөгжил сангийн төлөвлөгөөнд тусгагдсан "Өргөх станцын зураг төсөв боловсруулах ажил"-ыг хэрэгжүүлэх зорилгоор зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй хуулийн этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.

Батлагдсан төсөвт өртөг: -10,000,000 төгрөг

1. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- Байгууллагын гэрчилгээний наториатоор батлуулсан хуулбар
- Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрөл / наториатоор батлуулсан хуулбар, гэрээний хамт/
- Харилцагч Татварын алба, Нийгмийн даатгал, банк, Шүүх болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны тодорхойлолтууд
- Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт
- Сүүлийн 2 жилд хийж гүйцэтгэсэн ижил төрлийн ажлын туршлагын талаарх мэдээлэл

- Ажиллах боловсон хүчний чадвар, туршлагын мэдээлэл
Чадварыг нэмэгдүүлж сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.

2. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2017 оны 08 дугаар сарын 14-18-ны өдрүүдэд ажлын цагаар авч болох бөгөөд мэдүүлгээ дор дурдсан хаягаар 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 15.00 цагаас өмнө Говьсүмбэр аймаг, Баянтал сум, 1-р баг Засаг даргын Тамгын газрын байр, 2 давхар Худалдан аюах ажиллагааны мэргэжилтэнд цаасан хэлбэрээр ирүүлнэ үү.

Говьсүмбэр аймаг, Баянтал сум, 1 дүгээр баг,
Засаг даргын Тамгын газрын байр
Утас: 89945248, 94113190